

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4 дүгээр хавсралт

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/	
<p>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</p>	
Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/	2022 оны 01-р сарын 01-ний өдрөөс 2022 оны 12-р сарын 31-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	<p>“Улсын их дэлгүүр” ХК</p> <p>Регистрийн дугаар: 2117436</p> <p>Улсын бүртгэлийн дугаар: 9010001017</p> <p>Үнэт цаасны код: UID</p> <p>Утас: 89885120</p>
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж ТӨХК
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн үйл ажиллагаа
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	<p>“Сүлд-Аудит” ХХК</p> <p>Тайлан гаргасан огноо: 2023.02.08</p>
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	36,807,850 ширхэг
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	<p>Бэлтгэсэн: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат, Ахлах нягтлан бодогч Д.Чимгээ</p> <p>Хянасан: Гүйцэтгэх захирал И.Галбуян</p>
1	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/
	<p>Санхүүгийн байдлын үзүүлэлт</p> <p>2022 онд нийт хөрөнгийн дүн 16,413.0 сая төгрөг, үүнээс эргэлтийн хөрөнгө 7.0 хувь буюу 1,156.9 сая төгрөг, эргэлтийн бус хөрөнгө 93.0 хувь буюу 15,256.1 сая төгрөгийг эзэлж байна.</p> <p>Нийт эх үүсвэр 16,413.0 сая төгрөг , үүнээс өр төлбөр 18,917.6 сая төгрөг, эзний өмч -2,504.6 сая төгрөг байна.</p> <p>2022 оны санхүүгийн тайлан хавсаргав.</p>
	<p>Орлогын тайлан</p> <p>2022 онд түрээсийн орлогыг 10% нэмэгдүүлэн 6,858.2 сая төгрөгийн орлоготой, 6,469.1 сая</p>

		төгрөгийн зардалтай, 389.1 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. 2022 оны санхүүгийн тайлан хавсаргав.
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	2022 онд 389.1 сая төгрөгийн ашигтай ажиллаж оны эцэст эзний өмчийн дүн -2,504.6 сая төгрөг байна. 2022 оны санхүүгийн тайлан хавсаргав.
	Мөнгөн гүйлгээний тайлан	2022 онд бүх цэвэр мөнгөн гүйлгээ -167.6 сая төгрөг, оны эцсийн мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл 5.1 сая төгрөг байна. 2022 оны санхүүгийн тайлан хавсаргав.
1.1	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт	
	Хөндлөнгийн Аудитийн байгууллагаас “УИД” ХК-ийн санхүүгийн тайлан тэнцэл нь Монгол Улсын Сангийн Яамнаас баталсан “Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалт”, “Дансны үлгэрчилсэн заавар”-ын дагуу аккрузель сууриар бэлтгэгдсэн ба энэхүү тайлагналын суурь нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын стандарттай нийцэж байна гэж дүгнэсэн.	
1.2	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/	
	Улсын Их Дэлгүүр ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31ний өдрөөрхи санхүүгийн байдал, тайлант жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт болон мөнгө гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/-ын дагуу үнэн зөв толилуулсан байна.	
2	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл	
2.1	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Тус компани тайлант онд нийт 7,377.5 сая төгрөгийн орлого олж, 6,469.1 сая төгрөгийн зардал гарган, 519.3 сая төгрөгийн түрээсийн хөнгөлөлт үзүүлж 389.1 сая төгрөгийн ашигтай ажилласан.
2.2	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Эргэлтийн харьцаа 0.13 Шуурхай төлбөрийн харьцаа 0.1
2.3	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	Улсын их дэлгүүрт гарсан галаас үүссэн хохирлын барагдуулж, барилгын засвар, сэргээн босголтыг бүрэн дуусгаж ажилласан.
2.4	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	УИДХК нь 2022 онд санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэсэн гүйлгээ байхгүй.
2.5	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа,	УИДХК нь ХААН банкинд 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдөр 7.0 тэрбум төгрөгийн зээлийг

	баталгааны талаарх мэдээлэл;	төлсөн.
3	<p>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</p>	
	<p>1. “Номин реалтор” ХХК-тай 2022 оны 01-р сарын 01-ний өдөр байгуулсан UID/22/01 дугаартай Үл хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээ.</p> <p>2. “Юнион ойл” ХХК-тай 2022 оны 01-р сарын 01-ний өдөр байгуулсан UID/22/35 дугаартай Ашиглалтын үйлчилгээний гэрээ. /Улсын их дэлгүүрийн барилгын цахилгааны хэвийн ажиллагааг хангах/</p> <p>3. “Номин реалтор” ХХК-ийн Инженер техникийн салбартай 2022 оны 02-р сарын 28-ны өдөр байгуулсан UID/22/36 дугаартай Ажил гүйцэтгэх гэрээ. /Улсын их дэлгүүрийн барилгын 7-р давхарт цэвэр, бохир усны шугам угсрах/</p> <p>4. “И Номин” ХХК-тай 2022 оны 03-р сарын 28-ны өдөр байгуулсан UID/22/37 дугаартай Худалдах-худалдан авах гэрээ. /Шилэн хийцэнд наах хуулга худалдах авах/</p> <p>5. “Номин реалтор” ХХК-ийн Инженер техникийн салбартай 2022 оны 03-р сарын 01-ний өдөр байгуулсан UID/22/38 дугаартай Ажил гүйцэтгэх гэрээ. /Улсын их дэлгүүрийн барилгын 7.5-р давхрын буулгалтын ажил/</p> <p>6. “Номин холдинг” ХХК-ийн Номин дизайн салбартай 2022 оны 03-р сарын 17-ны өдөр байгуулсан UID/22/39 дугаартай Ажил гүйцэтгэх гэрээ /Улсын их дэлгүүрийн барилгын дээврийн парapedны хаалт, хашлаганд нерж гоёл хийх ажил/</p> <p>7. “Номин реалтор” ХХК-ийн Инженер техникийн салбартай 2022 оны 03-р сарын 17-ны өдөр байгуулсан UID/22/40 дугаартай Ажил гүйцэтгэх гэрээ. /Улсын их дэлгүүрийн барилгын 1-р давхарт жижүүрийн ариун цэврийн өрөөний цэвэр, бохир усны шугам угсрах, тоноглол суурилуулах ажил/</p> <p>8. “Номин реалтор” ХХК-тай 2022 оны 04-р сарын 15-ны өдөр байгуулсан UID/22/44 дугаартай Захиалагчийн хяналтын ажил гүйцэтгэх гэрээ. /Улсын их дэлгүүрийн барилгын ажилд компанийн өмнөөс захиалагчийн хяналт тавих/</p> <p>9. “Ухаалаг эрчим хүч” ХХК-тай 2022 оны 06-р сарын 02-ны өдөр байгуулсан UID/22/46 дугаартай Ажил гүйцэтгэх гэрээ. /Улсын их дэлгүүрийн барилгын 1 болон 5-р давхрын ажилчдын өрөө болон кинотеатрын хүлээлгийн хэсгийн цахилгааны ажил/</p> <p>10. “Ухаалаг эрчим хүч” ХХК-тай 2022 оны 06-р сарын 02-ны өдөр байгуулсан UID/22/47 дугаартай Ажил гүйцэтгэх гэрээ. /Улсын их дэлгүүрийн барилгын 2-р давхрын атриумын нэмэлт гэрэлтүүлэг, мөн 5-р давхрын гэрэлтүүлгийн ажил/</p> <p>11. “Номин холдинг” ХХК-ийн Номин дизайн салбартай 2022 оны 07-р сарын 01-ний өдөр байгуулсан UID/22/51 дугаартай Ажил гүйцэтгэх гэрээ. /Улсын их дэлгүүрийн барилгын гадна парapedны нерж яргуй хийж суурилуулах ажил/</p> <p>12. “Номин реалтор” ХХК-ийн Инженер техникийн салбартай 2022 оны 11-р сарын 01-ний өдөр байгуулсан UID/22/55 дугаартай Ажил гүйцэтгэх гэрээ. /Улсын их дэлгүүрийн усан хөшигний цэвэр, бохир усны шугам хоолой угсрах ажил/</p>	
4	Цалин урамшууллын мэдээлэл	
	УИДХК нь 2022 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин, НДШимтгэлд 10.1 сая төгрөг зарцуулсан байна.	
5	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	
	<p>➤ “Улсын их дэлгүүр” ХК нь компанийн засаглалын бүтцийн хувьд дараах бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:</p> <p>- Хувьцаа эзэмшигчдийн хурал,</p>	

	<ul style="list-style-type: none"> - Төлөөлөн удирдах зөвлөл, - ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, - Гүйцэтгэх захирал, - Ахлах нягтлан бодогч, - Тооцооны нягтлан бодогч <p>➤ Тайлант хугацаанд компанийн удирдлагын хүрээнд дараах үйл ажиллагаа явагдсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 04-р сарын 29-ний өдөр хуралдаж, компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт болон ТУЗ-ийн 2022 оны зардлын төсвийг баталсан. - ТУЗ-ийн хараат бус гишүүд 2022 оны 01-р сарын 02-ны өдөр хуралдаж “Номин холдинг” ХХК-ийн нэгдэлд хамаарах компаниудаас ашиглалтын үйлчилгээ авах эрх олгосон. - ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо 2022 оны 01-р сарын 07-ны өдөр хуралдаж компанийн жилийн үйл ажиллагааны тайланд хөндлөнгийн аудит хийх аудитын байгууллагыг сонгосон. - ТУЗ-ийн хараат бус гишүүд 2022 оны 01-р сарын 10-ны өдөр хуралдаж “Номин даатгал” ХХК-тай даатгалын гэрээ байгуулах тухай болон “Эрдэнэт хивс” ХХК-д сүлд мод худалдах тухай сонирхлын зөрчилтэй хэлцлийг баталсан. - ТУЗ-ийн хараат бус гишүүд 2022 оны 02-р сарын 08-ны өдөр хуралдаж “Номин даатгал” ХХК-иас авах даатгалын нөхөн төлбөрийн хэмжээг баталсан. - Төлөөлөн удирдах зөвлөл 2022 оны 02-р сарын 18-ны өдөр хуралдаж өнгөрсөн оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. - Төлөөлөн удирдах зөвлөл 2022 оны 03-р сарын 18-ны өдөр хуралдаж 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тов болон хэлэлцэх асуудлыг баталсан. - Төлөөлөн удирдах зөвлөл 2022 оны 03-р сарын 24-ний өдөр хуралдаж компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж дүгнэсэн, мөн компанийн 2022 оны бизнес төлөвлөгөөг баталсан. - Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд 2022 оны 04-р сарын 25-ны өдөр хуралдаж банкны зээлийг төлөх зорилгоор “Номин реалтор” ХХК-иас түрээсийн төлбөрийг урьдчилан авах, түрээслэгчид түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх асуудлыг шийдвэрлэсэн. - Төлөөлөн удирдах зөвлөл 2022 оны 08-р сарын 25-ны өдөр хуралдаж Худалдаа хөгжлийн банкнаас зээл авах асуудлыг шийдвэрлэсэн.
6	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл
	Ашиглалтын зардал хурдацтай өсөж байгаа, Улсын их дэлгүүрийн барилга насжилт өндөртэй, Ноогдол ашиг хуваарилах нөхцөл бүрдэхгүй байгаа.
7	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/
	<p>Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс 2022 оны 03-р сарын 08-ны өдрийн байдлаар татан авсан Үнэт цаас эзэмшигчдийн судалгаагаар компани нийт 43,605 хувьцаа эзэмшигчтэй байсан.</p> <p>2022 оны 03-р сарын 08-ны өдрийн байдлаар 5 болон түүнээс дээш хувь эзэмшиж байсан хувьцаа эзэмшигчид:</p> <p>1. Р.Содном - 16,575,925 ширхэг</p>

	2. Ш.Уламбаяр - 3,896,290 ширхэг 3. Ш.Баярсайхан - 2,049,032 ширхэг
8	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл
	Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлэх зорилгоор хувьцаа нэмж гаргаагүй.
9	Ногдол ашгийн мэдээлэл
	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 02-р сарын 18-ны өдрийн хурлын 22/05 дугаартай тогтоолоор 2021 оны үйл ажиллагааны орлогоос хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.
10	Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл
	Байхгүй
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:	
Овог, нэр: И.Галбуян Албан тушаал: “Улсын их дэлгүүр” ХК-ийн гүйцэтгэх захирал Гарын үсэг: (Тамга/тэмдэг)	Овог, нэр: Албан тушаал: “.....” ХХК аудитын компанийн гүйцэтгэх захирал Гарын үсэг: (Тамга/тэмдэг)
Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:	
Овог, нэр: Д.Чимгээ Албан тушаал: Ахлах нягтлан бодогч Гарын үсэг:	
Овог, нэр: М.Өлзийбат Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Гарын үсэг:	

Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу

Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.	
Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр/	2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	“Улсын их дэлгүүр” ХК /9010001067,, 89885120/
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Худалдаа, үйлчилгээ /Хүнсний дэлгүүр, барааны дэлгүүр/
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	36,807,850 ширхэг
Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Тайлан бэлтгэсэн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат, Ахлах нягтлан бодогч Д.Чимгээ, хянасан Гүйцэтгэх захирал И.Галбуян
1	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/
	Санхүүгийн байдлын үзүүлэлт
	Орлогын тайлан
	Өмчийн өөрчлөлтийн тайлан
	Мөнгөн гүйлгээний тайлан
2	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт
3	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт
3.1	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/
3.2	Хөрвөх чадвар боломжийн үзүүлэлт болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт
3.3	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга

	хэмжээний мэдээлэл	
3.4	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого	
4	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
5	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл	
6	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	
7	Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл	
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:		
Овог, нэр: И.Галбуян Албан тушаал: “Улсын их дэлгүүр” ХК-ийн гүйцэтгэх захирал Гарын үсэг: (Тамга/тэмдэг)		Овог, нэр: Албан тушаал: “.....” ХХК аудитын компанийн гүйцэтгэх захирал Гарын үсэг: (Тамга/тэмдэг)
Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:		
Овог, нэр: Д.Чимгээ Албан тушаал: Ахлах нягтлан бодогч Гарын үсэг:		